



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
С.БҮРЭНБАТ ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-2460,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2015.01.19 № 01/460
танай _____-ны № _____-т

Үнэлгээний дүнгийн тухай

Нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр шалгарсан “Баянзүрх консалтинг” ХХН, “Онч шийдэл” ТББ, “Нийгмийн бодлогын хөгжлийн судалгааны хүрээлэн” ТББ-ын төлөөлөл бүхий шинжээчдийн 4 баг Авлигатай тэмцэх газрын даргын тушаалаар баталсан “Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлэх аргачлал”-ын дагуу төрийн байгууллагуудын 2014 оны авлигын эсрэг үйл ажиллагаанд үнэлгээ хийж, үнэлгээний дүнг олон нийтэд мэдээлээд байна. Энэхүү үнэлгээ нь 2 дахь удаагаа хийгдэж байгаа бөгөөд Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын “Найм”-ын 61-д заасны дагуу төрийн захиргааны байгууллагын үнэлгээний нэг үзүүлэлт болдог.

Энэ удаагийн үнэлгээнд Улсын Их Хурлаас байгуулагддаг 7 байгууллага, 16 яам /хуучин бүтцээр/, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч 26 агентлаг /Хил хамгаалах ерөнхий газар, Зэвсэгт хүчний жанжин штаб, Тагнуулын ерөнхий газар үнэлгээнд хамрагдаагүй/, аймаг, нийслэл 22, нийслэлийн 9 дүүрэг, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 44 хуулийн этгээд, нийт 124 байгууллага хамрагдлаа. Үнэлгээ нь авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн биелэлтийг 0-70 оноо, авлигатай тэмцэх санал, санаачилгыг 0-30 оноо, нийт 100 оноогоор үнэлдэг бөгөөд Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар 61 оноотой үнэлэгдсэн нь өнгөрсөн оныхоос 16 оноогоор нэмэгджээ. Тодруулбал, авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн биелэлт 41 оноо, удирдлагын санал, санаачилга 20 оноотойгоор үнэлэгдсэн байна.

Ийнхүү жил тутам иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлж буй төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээний зорилго нь төрийн албанд шударга ёсыг бэхжүүлэх, хариуцлагыг чангатгах, нийтийн албаны үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хяналт тавих боломжийг тэдэнд олгох, хуулиар хүлээсэн үүргээ төгс биелүүлэх, авлигын эсрэг санал, санаачилгыг дэмжих, төрийн байгууллага хоорондын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байгаа юм.

Тус аймгийн Засаг даргын Тамгын газар нь 2013 онд авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээндээ дүгнэлттэй хандаж, Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн “Зөвлөмж”-ийн мөрөөр зохих арга хэмжээг авч хэрэгжүүлснээр өөрийн үнэлгээг амжилттай ахиулсныг сайшаан тэмдэглэж байна.

Шинжээчдийн баг нь дээрх үнэлгээг хийхдээ төрийн байгууллагын цахим хуудас дахь мэдээлэл, тухайн байгууллагаас ирүүлсэн тайлан, баримт бичгүүдэд тулгуурласан бөгөөд Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар зохих үнэлгээг бүрэн авахад дараахь нөхцөл байдлууд сөргөөр нөлөөлжээ:

000897

1/ Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авсан арга хэмжээ тодорхой бус; ?

2/ иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлээгүй; - ?

3/ Концессийн зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаар болон Концессийн гэрээ байгуулсан тухай бүр концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессийн зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг холбогдох хуульд заасан хугацаанд үндэсний хэмжээний өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлсэн эсэх нь тодорхой бус; .

4/ чиг үүргийн дагуу нууцад хамаарахаас бусад бүртгэлийн талаарх мэдээлэл, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтын болон гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр түүний хэрэгжилтийн нээлттэй байдлыг хангаагүй; -

5/ эрсдэлтэй ажил, албан үйлчилгээг гүйцэтгэж буй албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, авлигын эрсдэл гаргах боломжийг бууруулах чиглэлээр төрийн бус байгууллагатай хамтран ажиллах санаачилга дутмаг; ✓ .

6/ иргэдийн өргөдөл /санал/, гомдол, хүсэлтийн шийдвэрлэлтийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх, сурталчилах ажлыг хэвшүүлээгүй; ✓ .

7/ хуулиар болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулсан талаарх мэдээлэл байхгүй; - ?

8/ авлигын эсрэг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг тайланд тусгаагүй зэрэг болно.

Цаашид үнэлгээнд сөргөөр нөлөөлсөн дээрх асуудлуудад анхаарлаа хандуулахын зэрэгцээ “Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-д тусгасан шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажиллах, 2015 оны авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээний дүн /оноо/-г өмнөх оныхоос дээшлүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Дээрх асуудлаар тус газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, хамтран ажиллах болно.

Мөн 2015 онд хэрэгжүүлэх “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г боловсруулан баталж, 2015 оны 2 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Жич: “Шинжээчдийн баг”-ийн тайланг www.iaac.mn цахим хуудасны “урьдчилан сэргийлэх” цэсэнд байршуулсан болно.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР



Н. ГАНБОЛД